

## ОЮУТНУУДЫН СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД МЭРГЭЖИЛТЭН- БИЕ ХҮНИЙ ШИНЖ ТӨЛӨВШИХӨД ЧИГЛЭСЭН ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ АЖЛЫН ТОГТОЛЦООНЫ ТАЛААР ХИЙСЭН ТҮРШИЛТЫН ЗАРИМ ДҮНГЭЭС

**Н.ЦОГЗОЛМАА**

**Резюме:** Система внеклассных работ в пед вузах играет особую роль в формировании творческого гражданина и личности учителя у студентов. В этой рассмотрен о том, какие виды внеклассных работ возможны организовать в вузе.

### Түлхүүр үг:

*Мэргэжилтэн-бие хүний шинж төлөвших, хичээлээс гадуурх ажлын тогтолцоо, хэрэгжүүлэх арга хэлбэр*

Мэдээлэл технологийн энэ эрин зуунд боловсрол, түүний чанар, мэргэжилтний чадварын асуудал чухал байр суурь эзлэх боллоо. Боловсролыг багшгүйгээр төсөөлөхийн ч аргагүй юм. Тэр дундаа ирээдүйн багш буюу оюутан-багшийн хөгжил төлөвшлийн талаарх асуудал ирээдүйн төлөвшлийн асуудалтай, цаашилбал улс орны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зүйл болох нь гарцаагүй юм. Учир нь: Оюутан-багш яаж бэлтгэгдэж, яаж төлөвших нь ирээдүйд тийм л багш болж улс орныг хөтлөх иргэдийг тэр хэмжээгээр хөгжүүлж, төлөвшүүлэх, бэлтгэх болно. Иймээс оюутны тэр дундаа оюутан-багшийн сурах, хөгжиж, төлөвших асуудал хамгийн чухал асуудлын нэг юм.

Боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлэхэд оюутны сурах, хөгжих, төлөвших үйл ажиллагаа буюу “оюутны төлөвшил” төвт үйл ажиллагаа чухал юм. Яагаад? Мэргэжилтэй боловсон хүчин болоход мэргэжлийн мэдлэг, боловсролыг эзэмшүүлж чадаж байна. Харин мэргэжилтэй боловсон хүчний цаашид бие даан ажиллах чадвар, чадамж, төлөвшлийн асуудал үүнээс чухал тавигдах боллоо.

Тус Газарчин дээд сургууль 2006 оны 9 сарын 1-ээс түүх, газарзүйн багш бэлтгэж эхэлсэн. Багшийг эхнээс нь чанартай бэлтгэх үүднээс I курст элсэхэд нь /хичээлийн эхний хоёр долоо хоногт/ судалгаа аваад II курст дахин судалгаа авч төлөвшлийн явцын үр дүнг тогтоож, мөн 2006 онд элссэн оюутныг 2007 онд элссэн оюутантай харьцуулж үзлээ.

Судалгааг асуулга, ажиглалт, ярилцлагын аргуудаар авсан бөгөөд тус сургуулийн I, II курсийн 100 гаруй оюутан хамрагдсан. Судалгаанд хамрагдсан оюутнуудын хариултын давтамжийг тоолж, эрэмбэлэх аргаар боловсруулалт хийсэн бөгөөд курс бүрээр хувилж, өсөх буурах хувийн жинг тодорхойлон үнэлгээ өгсөн.

1. “Та энэ сургуульд ямар шалтгаанаар элссэн бэ?” гэсэн асуултад нийт судалгаанд хамрагсдын 31.3% /I курс/, 39.2% /II курс/, “Багш болох хүсэлтэй учир”, 37.2% /I курс/, 33.3% /II курс/ “Дээд мэргэжил эзэмших гэж, 7.8% /I курс/, 11.7% /II курс/ “Багшийн цалин нэмэгдэж байгаа учир” гэсэн хариултыг сонгосноос үзвэл өөрийн хүсэл сонирхлыг дагасан, зорилготой суралцах, мөн эдийн засаг, материаллаг зүйл зайлшгүй хэрэгтэй гэдэг нь харагдаж байна.

2. “Танд сурах хүсэл сонирхол хэр байна вэ?” гэсэн асуултад 39.2% /I курс/, 49.0% /II курс/ “Маш их” гэж 9.8%-иар өссөн, 11.7% /I курс/, 9.8% /II курс/ “Тааруухан” гэж хариулсан оюутны сурах хүсэл сонирхол өсөж байгаа, “тааруухан” гэсэн хариулт 1.9%-иар буурч байгаа энэ нийгэмд өөрөө өөрийгөө дайчлан ажиллах нь чухал гэсэн санаа гарч байгаа хэдий ч сурах хүсэл сонирхлоо мэдэхгүй 11.7% /I курс/, 7.8% /II курс/ оюутан байгаа нь тэд мэргэжлийн зөв сонголт хийгээгүйг харуулж байгаа ба “Хуваарь таарсан” гэсэн хариултыг 19.6% /I курс/, 9.8% /II курс/ сонгосон нь өөрийн хүсэлтээр сургуульд элсээгүй гэдэгтэй нийцэж байна.

3. “Таны багш болох хүсэл нэмэгдэж байна уу?” гэсэн асуултад “Тийм” гэсэн хариултад 27.4% /I курс/, 39.2% /II курс/, “Бага зэрэг” гэсэн хариултад 37.2% /I курс/, 45.0% /II курс/, “мэдэхгүй” гэсэн хариултад 17.6% /I курс/, 15.6% /II курс/, “үгүй” 9.8% /I курс/, 7.8% /II курс/ гэж хариулснаас үзэхэд курс ахих тусам багш болох хүсэл сонирхол нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Энэ мэргэжлийн хичээлүүд болон хичээлээс гадуурх ажил нөлөөлсөн гэж үзэж болох талтай.

4. “Таныг багшид төлөвшихөд сургалтаас гадна

өөр ямар ажил байж болох вэ?” гэсэн нээлттэй асуултад нийт 102 оюутан оролцсоноос давтамжийн хувийн жинг үзэхэд:

|                                     | Оюутны тоо | Хувь  | Эрэмбэ |
|-------------------------------------|------------|-------|--------|
| Ярилцах чадварт суралцах            | 91         | 89.2% | I      |
| Оюутныг нээхэд туслах сургалт       | 89         | 87.2% | II     |
| Удирдах арга барил                  | 86         | 84.3% | III    |
| Харилцах соёл                       | 78         | 76.4% | IV     |
| Хүүхэдтэй ажиллах арга барилд сурах | 76         | 74.5% | V      |
| Судалгааны ажил                     | 59         | 57.8% | VI     |
| Мэргэжлийн дугуйлан                 | 57         | 55.8% | VII    |
| Уралдаан тэмцээн                    | 45         | 44.1% | VIII   |

Оюутнууд ярих чадвар, өөрийгөө нээж хөгжүүлэх, удирдан зохион байгуулах чадваруудыг чухалд үзсэн байгаа нь харагдаж байна. Дээрх судалгааг авсантай холбогдуулан дараах тогтолцоог боловсруулж туршиж үзэхэд эхний хагас жилийн байдлаарх өөрчлөлтүүд дараагийн жилийн судалгаанаас харагдаж байна. /2006-2007 оны эхний хагас жил/ Хичээл, сургалтаас гадуурх ажлыг дараах дөрвөн чиглэлээр зохион байгуулж явуулах боломжтой бөгөөд оюутны төлөвшилд нөлөөлөхүйц юм гэж үзэж байна.

## I курст:

### 1. Оюутан ахуйд дасахад чиглэсэн үйл ажиллагаанууд.

**Зорилго:** Шинээр бүрэлдэж байгаа анги хамт олныг нэгдэл нягтралтай, эвсэг, хамтарч ажиллах, сурч, төлөвших, хөгжих үйл ажиллагаанд суралцуулах.

#### Зорилт:

а. Эхний байдлаар анги танхимдаа өөрийгөө хаанаас ирсэн хэн болох, өөрийн сонирхол, авьяас, онцлох зүйлээ хэлж товчхон танилцах

б. Анги хамт олон бүрэлдэх төлөвших хоёр дахь алхам тодорхой төлөвлөгөөний дагуу танилцах аялал, экскурс зохион байгуулах  
в. Ангийн зохион байгуулалт хийнэ. Тодорхой хугацаанд нэгнийхээ хэн болохыг таньсан учир ангийн идэвхтэн /дарга/ гишүүнийг сонгох. Энэ үйл ажиллагаа нь эхний 1-2 долоо хоногт зохион байгуулагдана.

### 2. Сурах арга барилд сурахад чиглэсэн үйл ажиллагаанууд.

**Зорилго:** бие даан суралцаж, хөгжиж, төлөвших зөв арга барилд сургах.

#### Зорилт:

- Лекц сонсох, тэмдэглэж сурах
  - Семинарт бэлтгэх, илтгэж сурах
  - Уншиж, судлах, номтой ажиллаж сурах
  - Бичиж тэмдэглэх
  - Бодлого бодох, дасгалтай ажиллах
  - мэргэжлийн нэр томъёотой танилцах, ажиллах чадваруудад дасгах, эзэмшүүлэх, төлөвшүүлэх.
- Энэ үйл ажиллагаа нь эхний хагаст жилээс нэг жилийн туршид хийгдэх болно.

### 3. Мэргэжилд чиглэсэн үйл ажиллагаанууд:

**Зорилго:** мэргэжилтэн-бие хүнд төлөвших, суралцах.

#### Зорилт:

- Мэргэжлийн дугуйлан, секцэд орж суралцах
- Мэргэжлийн ном материалд, болон холбогдох төхөөрөмжийг олж авах, ашиглах
- ажиглах, судлах, турших, тайлагнах, бичиж боловсруулах.

### 4. Олон нийтийн ажил буюу нийгэмд оюутны оролцоо чиглэсэн үйл ажиллагаанууд.

**Зорилго:** мэргэжилтэн-бие хүнд төлөвших, нийгмийн янз бүрийн харилцаанд оролцож өөрийгөө сорьж таних, бусдаас суралцах, бусдыг сонсох арга барилд суралцах

#### Зорилт:

а. Бусад мэргэжил нэгт их дээд сургуулийн болон гадаадын сургуулийн оюутан сурагчидтай харилцах

- Эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих
- Уран илтгэгчийн болон харилцах урлаг, удирдахуйн ухааны, мэдээлэл технологийн, гадаад хэлний гэх зэрэг дамжаанд суралцах
- Урлаг, спортын уралдаан тэмцээнд оролцох
- Төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудаас зохиогдож буй үйл ажиллагаануудад оролцох, суралцах /I-II курст суралцах хугацаанд/.

### Хэрэгжүүлэх арга хэлбэр: 1. Мэргэжлийн удиртгал хичээл. /тэг долоо хоногийн сургалт/

- Анги дотроо танилцах
- Мэдлэг, чадварын түвшин тогтоох
- Мэдлэг, чадварын доголдлыг засах, нөхөх
- Сурах арга барилын анхны дасгал сургуулилт

## 2. I улирлын явцад:

- Багш бүхэн оюутны сурах арга барилд зөвлөх, туслах
- Оюутны зөвлөл, “Сурах арга барилд суралцахуй” клубээс ярилцлага, семинар зохион байгуулах
- Аялал жуулчлалын “Ренжерс” клубийн явган аялал зохион байгуулах
- Суралцах чадварыг хөгжүүлэх сэдэвт 14-21 хоногийн ажил зохион байгуулах, олимпиад, уралдааныг зохион байгуулах
- Оюутанд зөвлөх төв /хамтлаг/ ажиллуулах
- Тэнхимүүд I курсийнхний суралцаж байгаа байдалд онцгой анхаарч ажиллах.

## I улирлын төгсгөлд бүх I курсийнхнээс сурах хандлага, төлөвшлийн чадварын тестээр шалгалт авах, үнэлэх.

/төлөвшлийн тусгайлан боловсруулсан тест/ 3. I курсийн II улирал болон II курсийн туршид 2-3 дугаар үйл ажиллагаануудад суралцаж байгаа байдалд хяналт тавьж “суралцах арга барилын клуб” мэтийн оюутны байгууллагад тэднийг татан оролцуулж, хамтран ажиллуулна.

## Дүгнэлт:

Оюутны төлөвшилд сургалтаас гадна олон талт үйл ажиллагаа буюу харилцах соёл, өөрийгөө таних,нээх чадвар,итгэл үнэмшил,илтгэх ур чадвар, мэргэжлийн болон урлаг спортын уралдаан тэмцээн,сэдэл тэмүүлэл, өөрийн үнэт зүйл, төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагын ажлын оролцоо, танин мэдэх, сурах, сургах чадвар чадамжуудаас багтаан үзэж байна. Мэргэжилтэн-бие хүний төлөвшихөд зөвхөн сургалт биш өөр олон хүчин зүйлүүд нөлөөлдөг болох нь тодорхой байна. Товчхон хэлбэл: Мэргэжилтэн-бие хүний нийгэмд өөрийгөө авч явах мэргэжлийн чадвар, ёс суртахууны хэм хэмжээ юм гэж үзэж байна. Иймээс мэргэжилтэн-бие хүний төлөвшлийг багш бэлтгэдэг сургууль бүхэн бүхэл бүтэн тогтолцоотойгоор зохион байгуулах шаардлагатай.

## Номзүй

- 1 О.А. Абдуллина Н.Н. Загрязкина. Педагогическая практика студентов М.,1986.
2. Монгол улсын боловсролын багц хууль УБ. 2002.
3. Багшийн хөгжлийн зарим арга зүйн асуудал. Ц.Оюун УБИС, МННХ /соросын сан/.
4. Багш бэлтгэх тогтолцооны хөгжлийн зарим асуудал Д.Нямжав. УБИС, МННХ /соросын сан/ УБ. 2003.
5. Нэгжид суурилсан судалгааны арга дүнгээс Д.Эрдэнэчулуун. УБИС,МННХ /соросын сан/ УБ. 2003.
6. Багшийн загварын нэгэн хувилбар О.Мягмар УБИС, МННХ /соросын сан/ УБ. 2003.
7. Монгол улсын их сургууль Мэргэжлийн Дидактийн Сургалт Судалгааны Төв Багш боловсролын хөгжлийн шинэ чиг хандлага.
8. Ч.Пүрэвдорж Боловсролын тогтолцоо олон улсад УБ., 1999.
9. Б.Жадамбаа, Ц.Батсуурь, Б.Пүрэв-Очир, Д.Пүрэвдорж Багш боловсролын шинэчлэлийн асуудалд “Багш-2005” төсөл УБ., 2003.
10. Клиник сургууль клиник профессор. Багш-2005 төсөл. МУБИС. УБ., 2005.
11. Боловсролын аж асуудлууд. Я. Хишигт, Х. Энхтөгс. УБ., 2007.
12. Багш боловсролын хөгжил шинэчлэл, МУБИС байгуулагдсаны 55 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ., 2006.